

Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидал – 2024 оны 6 дугаар сар

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Өнгөрсөн жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс хайгуулаас олборлогч руу шилжих томоохон өөрчлөлт, дэвшил гарч байгаад бид баяртай байна. Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй стратегийн түншлэл байгуулж, Баянхөндий алтны төсөл (“Төсөл”)-ийн бүтээн байгуулалтыг эхлүүлэн, Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуулын амжилтыг үргэлжлүүлсээр байна. Хорь гаруй жилийн турш Монгол Улсын баруун өмнөд бүсэд эрэл хайгуул, судалгааны ажлуудыг гүйцэтгэсний дүнд Эрдэнэ Ресурсийн үүсгэн байгуулагчдын алсын хараа биеллээ олж, дүүргийн хэмжээний нээлтийг хийж, 2025 оны дундуур Баянхөндийн олборлолтыг эхлүүлэхээр төлөвлөж байгааг мэдээлэхэд таатай байна.

Стратегийн түншлэл – Эрдэнэ Ресурс нь Монголын тэргүүлэх олборлогч компанитай хамтран ажиллахаар болов

2024 оны эхээр бид Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлэхээр ММС-тэй гүйцэтгэсэн стратегийн түншлэлийг эцэслэв. Монголын томоохон уул уурхайн олборлогч компани болох ММС нь манай охин компани Эрдэнэ Монгол (“ЭМ”) ХХК-д 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, тус компанийн 50%-ийг эзэмших болсон нь Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтад зарцуулагдаж байна. Эрдэнэ Ресурс нь Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-ийг эзэмшихээс гадна дээрх тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдээс 5 км-ийн хүрээнд эзэмших тусгай зөвшөөрлүүд дээр 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ”) авах нөхцөлтэй. Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн төслийг 100% эзэмшсэн хэвээр байна.

ММС-ийн гол хувьцаа эзэмшигч нь Монголын томоохон групп компаниудын нэг М-Си-Эс Групп юм. М-Си-Эс нь 30 гаруй жилийн хугацаанд Монгол Улсад инженерчлэл, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэнд болон үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ирсэн. Нийт 13,000 гаруй ажилтантай энэхүү групп нь Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг юм.



*Эрдэнэ Ресурс, ММС болон Эрдэнэ Монголын удирдах ажилтнууд
Баянхөндий төсөл - 2024 оны 5 сар*

М-Си-Эс группийн хөрөнгө оруулалттай М-Си-Эс Проперти нь Баянхөндий төслийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэхээр төслийн бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгч ("ЕРС")-ийн гэрээ байгуулсан. Мөн М-Си-Эс группийн хөрөнгө оруулалттай М-Си-Эс Интернэйшнл нь Хөндий Эрдсийн Дүүргийг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, эрчим хүч хангахаар төлөвлөсөн.

ММС-тэй стратегийн түншлэл байгуулсан нь Баянхөндий төслийг олборлолтын шат руу ахиулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Баянхөндий алтны орд – дэлхий дахинд илээр олборлох боломжтой хамгийн өндөр агуулга бүхий ордуудын нэг

2023 оны эцэст бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эцэслэснээр 2024 оны 1-р сард Эрдэнэ Ресурс болон ММС нь бүтээн байгуулалтын шийдвэрийг албан ёсоор гаргасан. 2024 оны 2-р сард бүтээн байгуулалтыг ажлуудыг эрчимжүүлж, 4-р сард хөдөлмөрийн чадвар түр алдалтгүй 1 сая хүн/цагийн амжилтыг тэмдэглэлээ. Бүтээн байгуулалт нь төсөв болон хуваарийн дагуу 25%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.



**Баянхөндий төслийн хөдөлмөрийн чадвар түр алдалтгүй 1 сая хүн/цаг
2024 оны 4 сар**

Өнөөг хүртэл төслийн голлох бүтээн байгуулалт нь боловсруулах үйлдвэрийн барилга болон структурын ажлуудад төвлөрсөн. Уурхай болон боловсруулах үйлдвэр нь жилд 650,000 тонн хүдэр боловсруулж, 85,000 унц алт олборлохоор төлөвлөж байна. Боловсруулах үйлдвэрийн голлох тоног төхөөрөмжүүд нь төслийн талбайд хүргэгдсэн, эсвэл тээвэрлэлтийн үе шатанд явж байгаа ба тээрмийн тоног төхөөрөмж өнгөрсөн долоо хоногуудад төслийн талбайд хүрсэн. Тоног төхөөрөмжүүд төслийн талбайд ирснээр бутлуур, тээрэм, уусгах танк, шүүлтүүр болон дамжуулагч, тэдгээртэй холбоотой цахилгаан хэрэгслүүд, угсралт, холбооны технологийн систем (“EICT”) зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн суурилуулах ажлуудыг хийж дуусгана. Түүнтэй зэрэгцэн кемп, засварын цех, агуулах, лаборатори зэрэг дэд бүтцийн ажлуудыг эрчимжүүлж байна.



*М-Си-Эс Проперти ХХК-ийн хамт олон
Баянхөндий төслийн талбай, 2024 оны 5 сар*



*Ил уурхайн төсөөллийг нэмсэн Баянхөндий төслийн зураглал
2024 оны 5 сар*



**Баянхөндийн төмөр хийцийн угсралт
2024 оны 5 сар**

Бүтээн байгуулалт нь 8-р сард оргил үедээ хүрэх буюу төслийн талбайд 650 гаруй ажилтан ажиллах бөгөөд оны эцэст бүтээн байгуулалтыг гүйцэтгэж дуусгахаар төлөвлөсөн. 2025 оны 1, 2-р улиралд улсын комисст хүлээлгэн өгөх, алт боловсруулах химийн бодисыг импортлох, ашиглах төр захиргааны байгууллагын зөвшөөрлийг авч, 2025 оны дундуур алтны олборлолтыг эхлүүлнэ. Алтны урьдчилсан олборлолтыг 60%, алт авалтыг 90%-д хүргэснээр 2025 оны 3-р улиралд олборлолтыг тогтворжуулна.

2023 онд Баянхөндий төслийн ТЭЗҮ-г шинэчилж, эерэг эдийн засгийн үр дүнг танилцуулсан. Шинэчилсэн ТЭЗҮ-ээр төслийн анхан шатны хөрөнгийн зардлыг (болзошгүй зардлыг оруулсан) 100 сая ам.доллар, нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг (“AISC”)-ийг 869 ам.доллараар тооцоолсон. Төслийн мөнгөн гүйлгээ нь алтны үнийн өөрчлөлттэй нягт холбоотой байх ба алтны үнэ нэг унц нь 100 ам.доллараар өсөх бүрд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) нь 25 сая ам.доллараар нэмэгдэнэ.¹

¹ Баянхөндий алтны төслийн шинэчилсэн ТЭЗҮ-ийг NI 43-101 Technical Report нэртэйгээр 2023.09.25 танилцуулсан. 2023.08.15-нд хүчин төгөлдөр болсон ТЭЗҮ-ийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR+ дахь компанийн хуудсаас танилцана уу.

Олон сая унцын нөөц бүхий дүүргийн хэмжээний нээлтүүд – Баянхөндийтэй зэрэгцээ алтны нээлтүүд

Баянхөндий алтны орд нь Хөндий-Улаан хувирлын бүсэд оршдог бөгөөд энэхүү бүсэд Хар Морь орд, Зүүн-өмнөд Улаан алтны хэтийн төлөв бүхий талбай болон хэд хэдэн хайгуул хийгдээгүй талбай багтдаг. Энэхүү хувирлын бүс нь олон сая унцын нөөц бүхий системийн онцлог шинжүүдийг агуулдаг тул уурхайн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх хэд хэдэн бүсийг нээн илрүүлэх, Баянхөндийн нөөцийг өсгөх боломжтой.




Баянхөндий ордын нөөц, ил уурхай болон зэрэгцээ нэг унц нь 2,000 ам.дол-оор төсөөлсөн нөөц²-ийн зураглал

Уурхайн ашиглалтын нөөцийн хязгаараас гадна нэмэлт нөөц тооцоолох боломжтой талбайнууд тодорхойлсон. Баянхөндий ордын алтны нөөцийг алтны үнэ нэг унц нь 1,800 ам.доллороор төсөөлсөн нь тооцоолол хийх үеийн алтны үнэлгээ юм. Одоогийн нэг унц алтны үнэлгээ 2,300 ам.доллар байгаа нь уурхайн ашиглалтын нөөцийн хязгаарын гадна орших нөөц нь эдийн засгийн хувьд ашигтайг харуулж байна.

Манай хайгуулын баг 2021 онд Баянхөндий ордоос хойд зүгт Урд Хар Морин Дэл хэмээх газрын дөт гүнд маш өндөр агуулга бүхий талбайг нээн илрүүлсэн. 2023 онд гүйцэтгэсэн Баянхөндийн шинэчилсэн ТЭЗҮ-д Урд Хар Морин Дэл талбайн нөөцийг багтаасан боловч Хойд Хар Морин Дэл, Зүүн Дэл болон Алтан Сум талбайнуудад харьцангуй хязгаарлагдмал судалгаа хийгдсэн тул нөөцийн тооцоололд багтаагүй. Гэвч дээр дурдсан талбай нь Баянхөндийн боловсруулах үйлдвэрт боловсруулах боломжтой алтны хүдэржилтийг агуулах боломжтойг харуулсан.

² Баянхөндий алтны төслийн шинэчилсэн ТЭЗҮ-ийг NI 43-101 Technical Report нэртэйгээр 2023.09.25 танилцуулсан. 2023.08.15-нд хүчин төгөлдөр болсон ТЭЗҮ-ийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR+ дахь компанийн хуудсаас танилцана уу.

2021 онд Баянхөндий ордоос баруун зүгт Зүүн-Өмнөд Улаан талбайг нээн илрүүлсэн. Нээлт нь 200*250 метрийн талбайг хамарсан хэдэн зуун метрийн алтны хүдэржилтээр (нэг цооногт 354 метр хүртэл) тодорхойлогддог ба дийлэнх хайгуулын цооногууд хүдэржилтээр төгссөн. Зүүн-Өмнөд Улаан талбайн хүдэржилтийн гүнийг тооцоолбол энэхүү талбайн тодорхой хэсгийг ил аргаар олборлох боломжтой. Цаашид Улаан болон Баянхөндий ордод далд олборлолт хийх боломжуудыг судалж байна.




Зүүн-Өмнөд Улаан талбайн онцлох цооногууд

Бид үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 5 жилийн стратегийн хайгуулын төлөвлөгөөг боловсруулсан. Бид энэ онд харьцангуй бага хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Баянхөндийн олборлолтыг эхлүүлснээр хайгуулын хөтөлбөрүүдийг эрчимжүүлнэ. Түүнээс гадна, тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна хэтийн төлөв бүхий талбайг судалж, сонгон шалгаруулалт болон хөрөнгө оруулалт хийх замаар тусгай зөвшөөрөл бүхий талбай эзэмших боломжуудыг судалсаар байна.

Алтан нар – Хөндий Эрдсийн Дүүргийн дараагийн хөгжүүлэлт

Хөндий-Улаан цогцолбороос хойд зүгт 16 км-т Алтан нар алт-полиметаллын орд оршдог. Алтан нар нь дундаж сульфиджилт бүхий карбонат-полиметаллт алтны (“СВМГ”) гэж ангилагддаг 5.6 км хүдэржсэн тренд бөгөөд гүндээ болон одоогоор мэдэгдэж буй судлын дагуу нээлттэй. Карбонат-полиметаллт алтны орд нь эпитеpmаль ордын дэд бүлэгт хамаардаг ба Баррик Гоулд компанийн Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонези), Лундин компанийн Фрута Дел Норте (Эквадор), Зижин компанийн Буритика төсөл (Колумби) зэрэг ордууд нь дээрх төрөлд багтдаг. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын

дээд хэсэгт тохиолдох ба эрдэсжилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.



Алтан нар хүдэржсэн тренд ба хайгуулын хэтийн төлөв бүхий бүсүүд

Алтан нар ордын нөөцийн тооцооллыг³ 2018 онд RPM Global гүйцэтгэсэн бөгөөд үүнд: 2.8 г/т дундаж агуулга бүхий 453,000 (алттай дүйцэх нэгжээр) унц, 5 сая тонн хүдэр бүхий бодитой нөөц; 2.5 г/т алтны дундаж агуулга бүхий 277,000 (алттай дүйцэх нэгжээр) унц, 3.4 сая тонн хүдэр бүхий боломжтой нөөц багтсан. Дээр дурдсан нөөцийн 90% нь газрын гадаргаас 150 метрт оршиж байгаа ба нөөцийг хүдэржилтийн трендийн дагуу 18 хэтийн төлөв бүхий талбайн 2-т нь гүйцэтгэсэн хайгуулын судалгаанд тулгуурлан тооцоолсон. Түүнээс гадна Алтан нар тусгай зөвшөөрлийн талбайд Оюут хөндий зэсийн хэтийн төлөв бүхий талбай, Номин тал зэс-алтны хэтийн төлөв бүхий талбай багтаж байна.

Бид өнгөрсөн онуудад Баянхөндий төслийн хөгжүүлэлтэд төвлөрсөн тул Алтан нар талбайд хязгаарлагдмал хайгуул хийсэн. 2020 оны 3 сард Алтан нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авснаар ирээдүйд хайгуул болон хөгжүүлэлт үргэлжлүүлэн хийх боломжтой. 2019 болон 2021 онд гүйцэтгэсэн судалгаагаар Алтан нарыг Баянхөндий ордтой хамт хөгжүүлэх боломжтой боловч бид нөөцийг нэмэгдүүлж, Алтан нарын хүдэрт тохирсон боловсруулах үйлдвэрийг байгуулах боломжтой гэж үзэж байна. Баянхөндийн олборлолтыг эхлүүлснээр бид Алтан нарын хайгуулыг эрчимжүүлнэ.

³ "Алтан нар Алт-полиметаллын төсөл, Баянхонгор аймаг, National Instrument 43-101 Техникийн тайлан" нэртэйгээр 2021.03.29-нд бүртгүүлсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг SEDAR+ дахь компанийн хуудаснаас авна уу.

Молибден-зэсийн порфирийн хэтийн төлөв – Хөндий Эрдсийн Дүүрэг

Хөндий Эрдсийн Дүүрэг нь дэлхийн томоохон үнэт металлын ордуудыг агуулдаг эпитеpmаль, карбонат-полиметаллт алтны ордуудын шинж чанарыг агуулдаг ба ихэвчлэн магмын арлан нумтай холбоотой гидротермаль системтэй холбоотойгоор газрын дөт гүнд оршдог. Эдгээр системүүд нь томоохон зэс, алт болон молибденийн порфирийн хүдэржилтийг агуулдаг бөгөөд 4 км хүртэл гүн үргэлжлэн, хүдэржилтийн давхцалуудаар тодорхойлогддог. Дэлхийн томоохон зэс-алтны орд болох Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт орших Рио Тинтогийн Оюу Толгой орд нь энэ төрлийн ордын голлох жишээ бөгөөд порфирийн зэсийн хүдэржилтийг өндөр сульфиджилт бүхий алт зэрэг хэд хэдэн үе шатны хүдэржилтээр бүрхэгдсэн нөөцийг агуулдаг. Хөндий Эрдсийн Дүүргийн хүрээнд хүдэржилт болон хувирлаас харвал энэхүү бүсэд томоохон порфирийн цөм эсвэл хэд хэдэн цөм орших боломжтой бөгөөд одоог хүртэл нээн илрүүлээгүй байна. Цаашид нарийвчилсан геофизикийн судалгаа болон өрөмдлөг гүйцэтгэн, гүн дэх порфирийн цөмийг илрүүлэх боломжтой.

Баянхөндий ордоос зүүн зүгт 35 км-т, БНХАУ-ын хилээс 200 км-т оршдог Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Зуун Мод порфирийн цогцолбор нь Ази тивд хөгжүүлэлт хийгээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэгийг агуулдаг. 2023 оны 5-р сард бид энэхүү талбайд 4,100 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэсэн. Энэхүү өрөмдлөгийн үр дүнд өнөөгийн нөөцийн хязгаарыг тэлж, ордын цөм дэх огтлолууд нь нөөцийн модель дэх хүдэржилтийг баталгаажуулсан. Мөн ордоос хойд зүгт 1.7 км-т хайгуулын цооногоор нөөцийн агуулга бүхий хүдэржилтийг нээн илрүүлсэн нь энэхүү томоохон зэс-молибденийн порфирийн цогцолбор нь бүх зүгт нээлттэйг харуулж байна. Молибденийн ордтой зэрэгцээ хэд хэдэн зэсийн хэтийн төлөв бүхий талбайд нэмэлт судалгаа, үнэлгээ хийх шаардлагатай. Эрдэнэ Ресурс нь 2021 оны эцэст RPMGlobal-ийн боловсруулсан төслийн үнэлгээнд үндэслэн зах зээл, техник болон эдийн засгийн судалгааг хийхээр төлөвлөж байна.

2023 оны эхээр молбиденийн үнэ бүх цаг үеийн дээд цэгт хүрсэн бөгөөд одоогоор нэг паунд молибден нь 30 ам.доллороор арилжигдаж байна. Зэвэрдэггүй гангийн үйлдвэрт ихэвчлэн ашигладаг молибденийг Канад, Австралийн засгийн газар, Дэлхийн банк, Олон улсын эрчим хүчний агентлаг зэрэг нь чухал ашигт малтмал гэж тодорхойлсон. Сэргээгдэх, цэвэр эрчим хүчний салбарт молибденийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Хэдийгээр эрэлт нь тогтвортой байгаа ч олборлолт буурч, уурхайнуудын ашиглалтад орох хугацаа хойшилж байгаа нь зах зээлийн нийлүүлэлтийг бууруулах хүчин зүйл болж байна. Ирээдүйн гурван жилийн хугацаанд молбиденийн зах зээлийн нийлүүлэлт 50 сая паундаар буурах төлөвтэй байна.

Бүс нутгийн хайгуул – уул уурхайн шинэ бүс нутаг


1990-ээд оны дундуур намайг Монголд ирэхэд Хөндий бүс нутаг нь хэт алслагдмал, геологийн системтэй хайгуул маш бага хийгдсэн бүс нутаг байсан. Намайг анх энэ бүсэд ирснээс 10-аад жилийн дараа АНУ-ын геологийн албаны (“USGS”) тайланд энэхүү бүс нутгийг “Алслагдмал байдал, эрс тэс уур амьсгал, дэд бүтэц хөгжөөгүй байдал зэрэг нь энэхүү бүс нутагт хайгуул хязгаарлагдмал хийх хүчин зүйл болсон” гэж онцолсон байдаг.⁴



Эрдэнэ Ресурсийн хайгуулын баг – 2006 он

Гэвч өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улс асар хурдацтай бүтээн байгуулалтыг өрнүүлсэн. Хурдны зам, аймгийн төвүүдэд шилэн кабель суурилуулж, Монгол Улс болон худалдааны хамгийн том түнш БНХАУ-ын хооронд авто зам, төмөр зам нэмэгдэж, хилийн сүлжээ үнэмлэхүй сайжирсан. Уул уурхайн салбарын өсөлт хөгжлийн хүрээнд эрчим хүчний сүлжээг өргөтгөн, хил дамнасан худалдааг хөнгөвчлөх зорилгоор Монголын боомтуудыг шинэчилж байна. Энэхүү дэд бүтцийн бүтээн байгуулалтууд нь Баянхөндий орд болон их хэмжээний түүхий эд боловсруулах Зуун Мод зэрэг төслүүдийн хөгжүүлэлтэд чухал ач холбогдолтой.

⁴ “Зүүн Азийн мезозойн үеийн порфирийн зэсийн үнэлгээ - БНХАУ, БНСВУ, БНАСАУ, Монгол Улс, ОХУ” Шинжлэх ухааны судалгааны тайлан, 2010-5090-G, USGS.



Монгол Улсын дэд бүтцийн бүтээн байгуулалт

Монголын жинхэнэ баялаг – ард түмэн ба соёл

Манай компани сүүлийн 20 гаруй жил, харин надад 30 гаруй жил энэ улсад ажиллах завшаан тохиосон. Намайг Монгол Улсад ирснээс хойш энэ улс дэлхийн хэмжээний зэс, нүүрс, алтны уурхайд тулгуурласан хүчирхэг, чөлөөт зах зээл бүхий ардчилсан системд шилжсэн. Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсээр ирсэн нь Оюу Толгой зэс-алтны ордын бүтээн байгуулалт дэлхийн хэмжээний уурхайнуудын нэг болоход нөлөөлсөн.



Эрдэнэ Монголын орон нутгийн баг

Баянхөндий төслийн хүрээнд бид усны хэрэглээг багасган, дахин боловсруулах; хаягдлыг усгүйжүүлэх зэргээр байгаль орчны нөлөөллийг бууруулах хүчин чармайлтыг гаргасаар ирсэн. Эрдэнэ Монгол нь орон нутгийн онцлог ургамлыг тарих, ургуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, уурхайн хойд хэсэгт хүлэмжүүдийг байгуулснаас гадна Эхийн голын баян бүрдийн газар тариаланг дэмжсээр ирсэн. Мөн манай тусгай зөвшөөрлийн талбайгаас 100 гаруй км зайд орших дархан цаазат газарт орших ховордсон мазаалай баавгайн амьдрах орчин хамгаалах, сайжруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж байна.



Баянхөндий ургамалжуулалтын талбай – 2024 оны 5 сар

Эрдэнэ Монгол ХХК нь одоогийн байдлаар шууд бусаар 700 гаруй иргэнийг ажлын байраар хангаж байгаагаас 99% нь монгол иргэд байна. Ажилтнуудын 30 гаруй хувь нь Баянхонгор аймаг болон Баянхөндий төслийн талбайтай хамгийн ойр суурин газар болох Шинэжинст сумын иргэд байдаг. Баянхөндий төслийн талбай дээр ажиллаж буй ажилтнуудын 28% нь эмэгтэй ажилтнууд. Түүнээс гадна, Баянхөндий төсөл нь монголчууд дангаар бүтээн байгуулалтыг хийсэн анхны томоохон уурхай болно. Энэхүү ажилд оролцож буй баг хамт олон нь Монголын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх бүтээн байгуулалтын үндэс суурь юм.



1,000,000 LTI FREE MAN-HOURS


Баянхөндий төслийн бүтээн байгуулалт ба хамт олон – 2024 оны 5 сар

Дүгнэлт

Өнгөрсөн жил манай компанийн хувьд хайгуулаас олборлолт руу шилжих томоохон өөрчлөлт, шинэчлэлтийн жил болж өнгөрлөө. 2025 онд олборлолтыг эхлүүлэх Баянхөндий төсөл нь бусад хайгуулын төслүүдийг эрчимжүүлэх, Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлэх суурь төсөл юм. Хөндий Эрдсийн Дүүргийн голлох үнэт болон үйлдвэрлэлийн металлын эрэлт, үнийн өсөлт нь Эрдэнэ Ресурсийн хэтийн хөгжлийг дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Бид ирэх жилүүдэд Хөндий Эрдсийн Дүүргийн өгөөжийг нэмэгдүүлэн, бүх оролцогч талуудтайгаа хуваалцахыг тэсэн ядан хүлээж байна.

Төгсгөлд нь би шаргуу хөдөлмөрлөж буй баг хамт олон болон хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье. Угтах он жилүүдэд бид илүү их амжилтыг хүлээж байна.

Хүндэтгэсэн,



Петер К. Акерли
Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал
2024 оны 6 сар



RD ERDENE
RESOURCE DEVELOPMENT

TSX:ERD | MSE:ERDN

Мэргэшсэн этгээд

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэхүү Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидлын техникийн мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

Урьдчилсан таамаглал

Уг мэдээлэлд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг мэдэгдэж байна. Энэхүү хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидалд багтаасан мэдээлэлд урьд нь танилцуулж байсан Баянхөндий төслийн олборлолтын хугацаа, бүтээн байгуулалт, улсын комиссын хугацаа, нөөцийн боломжууд, хайгуулын өрөмдлөг, санхүүгийн үр дүнгүүд, болон компанийн бусад хүлээгдэж буй мэдээллүүдээс бусад нь урьдчилсан таамаглал болно. Зарим нэг тодорхойгүй болон урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай. Эдгээр хүчин зүйлд материаллаг байдлаас хамааран зах зээлийн үнэ, хайгуул болон олборлолтын үр дүн болон ерөнхий эдийн засаг, зах зээл, бизнесийн нөхцөл байдлууд орно. Урьдчилсан таамаглал нь төсөөлөл болон тооцоололд тулгуурласан бөгөөд дээрх мэдээлэл, мэдэгдлүүд нь үндэслэлтэй гэж үзэж байгаа боловч бизнес, эдийн засаг болон өрсөлдөх чадвартай холбоотой тодорхойгүй, тооцоологдоогүй байдлыг үүсгэх боломжтой. Энэхүү хүчин зүйлд, (үүгээр хязгаарлагдахгүй) эрдсийн бүтээгдэхүүний үнэ, эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, Компанийн нөөцийн тодорхойлох чадвар зэрэг багтана.

Дээрх эрсдэлүүд гарч, компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх тохиолдолд энэхүү урьдчилсан таамаглал, мэдэгдэлд тусгагдсанаас өөрөөр нөлөөлөх, материаллаг өөрчлөлт гарах боломжтой. Эрдсэлийн хүчин зүйлс нь Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх бүх хүчин зүйлсийн жагсаалт биш юм. Нэмэлт хүчин зүйлсийг www.erdene.com-оос, эсвэл www.sedar.com-д тайлагнаснаар танилцаж болно.

Холбогдох үнэт цаасны хууль тогтоомжоор тодорхойлсон энэхүү Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидлын аливаа санхүүгийн хэтийн төлөв эсвэл санхүүгийн төсөөллүүдийг Хувьцаа эзэмшигчдэд хүргэх өдрийн байдлаар компанийн удирдлага боловсруулсан болно. Хэтийн төлөв эсвэл санхүүгийн төсөөлөл нь удирдлагын ирээдүйн хүлээлт, төлөвлөгөөний талаар мэдээлэл өгөх зорилготой. Иймд тайлагнаснаас бусад зорилгоор ашиглахгүй байх тухай уншигчдад анхааруулж байна. Энэхүү мэдээлэл нь англи хэл дээр бэлтгэгдсэн мэдээллийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.